



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/379

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны XIV хуралдааны "Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" XIV/01 дүгээр тогтоол, аймгийн "Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хууль эрх зүй, бодлого хөтөлбөрийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, хамтарсан баг, сургууль цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийн гишүүдийг арга зүйгээр хангах, санал хүсэлтийг сонсох зорилгоор хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн зөвлөгөөнийг зохион байгуулсугай.

2. "Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн зөвлөгөөн"-ийг зохион байгуулахад шаардагдах 2,700,000 (хоёр сая долоон зуун мянга) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн Хүүхэд хамгааллыг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

3. Тус арга хэмжээг төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр ханган хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 17-ны өдрийн А/З/С дугаар
захирамжийн хавсралт



“ХАМТАРСАН БАГ-ХҮҮХДИЙН ӨМНӨ ҮҮРЭГ ХҮЛЭЭГЧДИЙН
ЗӨВЛӨГӨӨН”-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар				
1	Гарын авлага, дэвтэр	150	10,000	1500,000
2	Бал	150	500	75,000
3	Мандат	150	1500	225,000
4	Сургалтын цаас, хэрэглэгдэхүүн /багц/	15	10,000	150,000
5	Бичгийн цаас	3	19,000	57,000
6	Принтерийн хор	2	70,000	140,000
7	Сургагч багшийн зардал	4	350,000	1,400,000
8	Цайны завсарлага	300	3500	1,050,000
Нийт				4,597,000
Аймгийн Засаг даргын Тамгын газар				
1	Хоол	150	18,000	2,700,000
Гэмт хэргээс зохицуулах зөвлөл				
1	Сурталчилгааны материал	2000	1000	2,000,000
Нийт				9,297,000
Үүнээс: 2,700,000 (хоёр сая долоон зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн Хүүхэд хамгааллыг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас				